МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР: ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Судалгааны төрөл: **Харьцуулсан судалгаа**
Судалгааны код: **СТ-25/210**
Хугацаа: 2025.03.08

ЗАХИАЛАГЧ: УИХ-ын гишүүн Х.Ганхуяг

Хянасан: ПСХХ–ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт

Судалгаа удирдсан: ПСХХ-ийн Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр

Судлаач: ПСХХ-ийн Эдийн засаг, байгаль орчин, хөдөө аж ахуй судалгааны хэсгийн Референт Р.Нургүл

Улаанбаатар хот
2025

Агуулга

Удиртгал 3

НЭГ. ТАТВАРЫН УРАМШУУЛЛЫН БОДЛОГО 4

1.1 Бизнес эрхлэгчид чиглэсэн татварын урамшууллын бодлого 4
1.2. Улс орнуудын татварын урамшууллын бодлого 5

ХОЁР. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН УРАМШУУЛАЛ 8

2.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээ 8
2.2 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 10
2.3 Улс орнуудын хэрэгжүүлж буй хурдасгасан элэгдэл хорогдол тооцох, зардлыг нэмэгдүүлэх урамшуулал 13

Судалгааны үр дүн 14

Ном зүй 15

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан улсуудын хэрэгжүүлж буй татварын урамшуулал..... 5
Хүснэгт 2. Судалгаанд авагдсан улсуудын татварын хувь хэмжээ 8
Хүснэгт 3. Судалгаанд авагдсан улсуудын татварын стандарт болон хөнгөлөлттэй хувь хэмжээ, хөнгөлөлт үзүүлж буй салбарууд 9
Хүснэгт 4. Хөнгөлөлт болон чөлөөлөлтийн ялгаа..... 10
Хүснэгт 5. Судалгаанд авагдсан улсуудын төлбөл зохих татварын хөнгөлөлт болон чөлөөлөлтийг хэрэгжүүлж буй туршлага 11
Хүснэгт 6. Судалгаанд авагдсан улсуудын хөрөнгө оруулалт болон зардлын хувиар татварын хөнгөлөлт үзүүлж буй туршлага 12
Хүснэгт 7. Судалгаанд авагдсан улсуудын хурдасгасан элэгдэл хорогдол тооцох, зардлыг нэмэгдүүлэх хөнгөлөлтийг хэрэгжүүлж буй туршлага 13

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МТ	Мэдээллийн технологи
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХАА	Хөдөө аж ахуй
ХО	Хөрөнгө оруулалт
ӨТ	Өндөр технологи
ЭЗ	Эдийн засаг

Удиртгал

УИХ-ын гишүүн Х.Ганхуягийн захиалгаар “Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар: гадаад орнуудын туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Судалгаанд авагдсан улсуудын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын туршлагыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Ирланд Улс, Бүгд Найрамдах Итали Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улс, Арабын Нэгдсэн Эмират Улс, Бүгд Найрамдах Эстони Улс зэрэг 8 улсын туршлагыг авч үзэв.

Судалгаанд авагдсан улсуудын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогын талаар судалсан болно.

Судалгааны ажлын бүтэц: Судалгаа 2 бүлэгтэй. Нэгдүгээр бүлэгт, бизнес эрхлэгчдэд чиглэсэн татварын урамшууллын бодлогын талаар, хоёрдугаар бүлэгт аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлт болон хурдасгасан элэгдэл хорогдол тооцох, зардлыг нэмэгдүүлэх замаар татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудлыг хамруулсан болно.

Судалгааны арга зүй: Судалгааг тухайн улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсын байгууллагуудаас эмхлэн гаргасан судалгаа, зөвлөмж, болон бусад мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдын бүтээлд тулгаарлан судалгааны удирдамжид заасан чиглэлийн дагуу холбогдох мэдээллийг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглан гүйцэтгэв.

Түлхүүр үг: *татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ААНОАТ, татварын урамшуулал*

Key words: *tax, corporate tax, corporate income tax, CIT, tax incentives*

НЭГ. ТАТВАРЫН УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

1.1 Бизнес эрхлэгчид чиглэсэн татварын урамшууллын бодлого

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшууллын бодлого нь хөрөнгө оруулалт, бизнесийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангаж, ажлын байрыг бий болгох төрийн сангийн бодлогын нэг хэлбэр юм. Ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд татварын урамшууллын бодлогоор дамжуулж хөрөнгө оруулалт татах нь эдийн засагт дутагдаж буй санхүүгийн хэрэгцээг хангах чухал арга хэрэгсэл болж байна.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг засгийн газар, эрх бүхий байгууллагын шийдвэрээс илүү хуульд тодорхой зааж өгөх нь татварын бодлогыг илүү шударга, ил тод, үр өгөөжтэй болгоно.

Тусгайлсан татварын зохицуулалт хийх замаар хөрөнгө оруулалт, аж ахуйн нэгж (цаашид ААН гэх), бараа бүтээгдэхүүнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олгох нь татварын урамшууллын бодлого юм. Татварын урамшуулал нь ерөнхийдөө татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэлбэртэй байдаг. Олон улсын туршлагад дараах нийтлэг хэлбэрүүд байна (Stotsky, 2024).

- **Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт**. ААН эсвэл хөрөнгө оруулалтын төсөл нь тодорхой хугацаанд татвараас чөлөөлөгдөх эсвэл тодорхой хугацаанд ААНОАТ-ын хөнгөлөлт буюу бууруулсан хувь хэмжээг мөрдөх боломжтой байдаг. Мөн алдагдлаа хөнгөлөлт, чөлөөлөлтийн хугацаанд татвар ногдох орлогод тооцуулах боломжтой.
- **Хурдасгасан элэгдэл хорогдол, зардлаа нэмэгдүүлэх**. Зарим төрлийн хөрөнгө оруулалтад нэмэгдсэн хувь хэмжээгээр элэгдэл хорогдол тооцуулах боломжтой. Ингэснээр татвар ногдох орлогыг бууруулах боломж бүрддэг. Мөн зарим төрлийн зардлыг нэмэгдүүлсэн хувиар тооцуулж татвар ногдох орлогоос хасуулах боломжтой.
- **Хөрөнгө оруулалтын хөнгөлөлт**. ААН-үүд оруулсан хөрөнгө оруулалтын зардлын тодорхой хэсгийг төлөх татвараасаа хөнгөлүүлж болно.
- **Бусад төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт**. НӨАТ, импортын татвар болон газрын төлбөр, хураамж зэрэг бусад төрлийн татвар, хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжтой.
- **Эдийн засгийн болон экспортын тусгай бүсийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт**. Зарим бүс нутаг, эдийн засгийн болон экспортын тусгай бүсэд хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа явуулж буй ААН-д олон төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлдэг.
- **Бусад төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлт**. Ноогдол ашиг болон хүүгийн орлогын татвараас хөнгөлөх, чөлөөлөх боломжтой. Ажиллах хүчтэй холбоотой татвар, хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж болно.

Дэлхийн улс орнуудын хувьд хөгжингүй орнуудаас илүү хөгжиж буй орнууд олон төрлийн татварын урамшууллыг ашиглаж байна (Stotsky, 2024).

Сүүлийн 10 жилийн хугацаанд дэлхийн 100 орны авч хэрэгжүүлсэн татварын урамшууллын бодлогыг судалсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Худалдаа хөгжлийн бага хурал (UNCTAD)-ын 2022 оны судалгаагаар үнэмлэхүй тооны улс орнуудын татварын урамшууллын бодлого нь гадаадын болон дотоодын ААН-д адил татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн байна (Stotsky, 2024).

1.2. Улс орнуудын татварын урамшууллын бодлого

Судалгаанд хамруулсан улсуудын татварын урамшууллын төрөл, зорилго, хэлбэрүүд ямар байгааг хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан улсуудын хэрэгжүүлж буй татварын урамшуулал

Улс	Урамшууллын төрөл	Урамшууллын зорилго	Хөнгөлөлт, чөлөөлөлт
Вьетнам (Vietnam briefing, 2024)	- ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт; - бусад төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт; - эдийн засаг (ЭЗ) болон экспортын тусгай бүсийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт.	- аж үйлдвэр, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалт (ХО) татах; - өндөр технологи болон мэдээлэл технологийн салбарыг хөгжүүлэх; - нийгмийн ач холбогдол бүхий салбарт ХО татах; - ЭЗ-ийн тусгай бүсийг хөгжүүлэх; - нийгэм, ЭЗ-ийн хөгжил сул бүс нутгийг хөгжүүлэх.	- ААНОАТ-ын хувь хэмжээг бууруулах; - ААНОАТ-аас чөлөөлөх; - төлбөл зохих ААНОАТ-ыг бууруулах; - импортын татвараас чөлөөлөх; - газрын төлбөрөөс чөлөөлөх.
Ирланд (Revenue Irish tax and Customs, 2024)	- ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт; - хурдасгасан элэгдэл хорогдол, зардлыг нэмэгдүүлэх; - ХО-ын хөнгөлөлт.	- кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх; - өндөр технологийн судалгаа, шинжилгээнд ХО татах; - инновац, мэдлэгт суурилсан бизнес, ногоон бизнесийг хөгжүүлэх; - байгаль орчинд ээлтэй ойн аж ахуйн бизнесийг дэмжих; - цахим тоглоом хөгжүүлэлтийн салбарыг дэмжих.	- кино үйлдвэрлэлийн зардлын тодорхой хувийг төлбөл зохих татвараас суутгуулах; - судалгаа, хөгжүүлэлт (анг.R&D)-ийн зардлын тодорхой хувийг төлбөл зохих татвараас суутгуулах; - патент, оюуны өмчийн орлогын татварын тодорхой хувийг хөнгөлөх; - эрчим хүч хэмнэсэн технологид хурдасгасан элэгдэл хорогдол тооцох; - групп компанийн алдагдлыг шилжүүлэн тооцох; - ААНОАТ-аас чөлөөлөх.
Итали (PwC, 2025)	- ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт; - хурдасгасан элэгдэл хорогдол, зардлыг нэмэгдүүлэх; - ХО-ын хөнгөлөлт; - ЭЗ-ийн бүсийн хөнгөлөлт, чөлөөлөлт; - бусад төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлт.	- Өмнөд Италийн бүс нутгийг хөгжүүлэх; - Итали улсад үйлдвэрлэлээ шилжүүлэхийг дэмжих; - ногоон ЭЗ-ийг хөгжүүлэх; - 4-р үеийн аж үйлдвэрлэлийг (Industry 4.0) дэмжих; - шинэ технологийн R&D-г дэмжих; - хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;	- ХО-ын зардлын тодорхой хувийг төлбөл зохих татвараас суутгуулах; - төлбөл зохих татвараа хөнгөлүүлэх; - ААНОАТ-ын хувь хэмжээг бууруулах; - шинээр байгуулсан ажлын байр бий болгохтой холбоотой зардлыг нэмэгдүүлсэн хувиар тооцуулах;

		- инновац, мэдлэгт суурилсан бизнесийг хөгжүүлэх; - хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх.	- ААН-ийн төлөх НДШ-ийн төлбөрийг хөнгөлөх; - судалгаа шинжилгээний зардлыг нэмэгдүүлж тооцох.
Казахстан (PwC, 2024)	- ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт; - бусад төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт; - ЭЗ-ийн бүсийн хөнгөлөлт, чөлөөлөлт.	- ЭЗ-ийн тусгай бүсүүдэд ХО татах замаар бүс нутгийн хөгжлийг хангах; - ХАА-г дэмжих бодлого; - Астанагийн олон улсын санхүүгийн төвийг хөгжүүлэх.	- ААНОАТ-ын хувь хэмжээг бууруулах; - ААНОАТ-аас чөлөөлөх; - төлбөл зохих татварын хувь хэмжээг хөнгөлөх; - ХО-ын зардлыг татвараас суутгуулах; - импортын татварын хөнгөлөлт, чөлөөлөлт; - бусад татварын чөлөөлөлт.
Хятад (PwC, 2025)	- ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт; - бусад төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт; - ЭЗ-ийн болон экспортын тусгай бүсийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт; - хурдасгасан элэгдэл хорогдол, зардлыг нэмэгдүүлэх.	- ХАА-н салбарыг дэмжих; - дэд бүтцийн ХО-ыг дэмжих; - инновац, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх; - программ хангамжийн үйлдвэрлэлийг дэмжих; - хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийг дэмжих; - ЭЗ-ийн хөгжил сул бүс нутгийг хөгжүүлэх.	- ААНОАТ-ын хувь хэмжээг бууруулах; - ААНОАТ-аас чөлөөлөх; - төлбөл зохих татварын хувь хэмжээг хөнгөлөх; - ХО-ын зардлын тодорхой хувийг төлбөл зохих татвараас суутгуулах; - импортын татварын хөнгөлөлт, чөлөөлөлт; - зарим тоног төхөөрөмж, хөрөнгөд хурдасгасан элэгдэл хорогдол тооцоох; - R&D зардлыг нэмэгдүүлэн тооцох; - бусад татварын хөнгөлөлт.
Орос (Trading economics, 2025)	- ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт; - бусад төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт; - ЭЗ болон экспортын тусгай бүсийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт;	- Мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх; - импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх; - ЭЗ-ийн тусгай бүс байгуулах замаар бүс нутгийг хөгжүүлэх.	- ААНОАТ-ын хувь хэмжээг бууруулах; - ААНОАТ-аас чөлөөлөх; - төлбөл зохих татварын хувь хэмжээг хөнгөлөх; - ХО-ын зардлын тодорхой хувийг төлбөл зохих татвараас суутгуулах; - импортын татварын хөнгөлөлт, чөлөөлөлт; - бусад татварын чөлөөлөлт; - R&D зардлыг нэмэгдүүлж тооцох.
Эмират (PwC, 2024)	- ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт; - ЭЗ-ийн болон экспортын тусгай бүсийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт.	- ЭЗ-ийн тусгай бүсүүдэд ХО татах.	- ААНОАТ-аас чөлөөлөх; - групп компанийн ашиг, алдагдлыг шилжүүлэн тооцох.
Эстони	0% ААНОАТ хэрэгжүүлдэг. Европ дахь бизнесийн төв болох, олон улсын компаниудыг татах зорилготой.		

(Estonian tax and Customs board, 2025)	

Судалгаанаас харахад, хөгжингүй орнуудын татварын урамшууллын бодлого нь голдуу шинэ технологи, инновацын судалгаа хөгжүүлэлт, ногоон эдийн засгийг бий болгоход чиглэж байна. Хөгжингүй орнууд болох Итали, Ирланд нь гол төлөв хөрөнгө оруулалтын зардлыг татвараас суутгах урамшууллын хэлбэрийг үзүүлж байна. Харин Эстони улсын хувьд 0%-ийн ААНОАТ хэрэгжүүлдэг онцлогтой байна. Эстони улсын 0%-ийн ААНОАТ нь бизнесүүдийг урт хугацаанд тогтвортой хөгжихөд чиглэсэн, хөрөнгө оруулалтыг дэмжсэн инновацлаг татварын бодлогод тооцогддог. Энэ нь тус улсыг Европ дахь бизнесийн төв болгож, олон улсын компаниудыг татах стратегийн нэг хэсэг болж байна.

Харин хөгжиж буй орнуудын хувьд татварын хувь хэмжээг бууруулах, татвараас чөлөөлөх аргаар татварын урамшууллыг түлхүү үзүүлж байна. Мөн эдийн засгийн тусгай бүс байгуулан түүнд хөрөнгө оруулж, үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдэд татварын урамшуулал үзүүлж байна.

ХОЁР. АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН УРАМШУУЛАЛ

Татварын урамшууллын бодлогын үндсэн хэлбэр нь ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлэх явдал юм. ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт нь тухайн хөрөнгө оруулалтын өгөөжид шууд нөлөөлдөг татвар тул улс орнууд, ялангуяа хөгжиж буй орнууд ААНОАТ-ын хөнгөлөлтийг гадаадын хөрөнгө оруулагчдад өргөнөөр үзүүлж байна.

ААНОАТ-ын чөлөөлөлт нь татвараас тодорхой хугацаанд эсвэл бүрэн чөлөөлөх замаар ААН-д дэмжлэг үзүүлнэ. Хөнгөлөлт нь татварын хувь хэмжээг бууруулж тооцох, эсвэл хөрөнгө оруулалт, зарим төрлийн зардлыг төлбөл зохих татвараас суутгаж ААН-ийн төлөх татварыг бууруулах замаар дэмжлэг үзүүлнэ (судалгаа ба хөгжүүлэлт, тоног төхөөрөмж, байгальд ээлтэй технологийн зардал гэх мэт). ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт үндсэн 2 төрөлтэй байна. Үүнд:

1. **Орлогод чиглэсэн хөнгөлөлт, чөлөөлөлт**. Татварын хувь хэмжээг бууруулж татвараас хөнгөлөх болон чөлөөлөх;
2. **Зардалд суурилсан хөнгөлөлт, чөлөөлөлт.** Хөрөнгө оруулалтын болон судалгаа хөгжүүлэлт, тоног төхөөрөмжийн гэх мэт зардлын тодорхой хувийг төлбөл зохих зардлаас суутгах, мөн хурдасгасан элэгдэл хорогдол тооцох замаар татвар ногдох орлогыг бууруулах.

2.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээ

Дэлхийн улс орнуудын ААНОАТ-ын хувь хэмжээ харилцан адилгүй бөгөөд тухайн улсын эдийн засгийн бодлого, татварын системээс хамааран өөр өөр байдаг.

Хүснэгт 2. Судалгаанд авагдсан улсуудын татварын хувь хэмжээ

Улс	ААНОАТ-ын хувь хэмжээ	
Вьетнам (Vietnam Briefing, 2025)	20% 25%-50% 32%-50%	- Газрын тос, байгалийн хийн олборлолт; - Үнэт метал, үнэт чулуу болон зарим төрлийн метал олборлолт.
Ирланд (Revenue, Irish tax and Customs, 2025) (PwC, 2025)	12.5% 25% 33%	- Татварын хууль (Tax Consolation Act) 2 дугаар бүлэгт заасан орлогууд болон түрээс, арилжааны орлого г.м; - хөрөнгө оруулалтын өгөөж.
Итали (PwC, 2025)	24% 3.9%	- орон нутгийн татвар
Казахстан (PwC, 2024)	20%	
Хятад (PwC, 2025)	25%	
Орос (Trading economics, 2025)	20%	(2025 оноос 25%)
Эмират (PwC, 2024)	0% 9%	375,000 дирхам (102,110.28 ам.доллар)-аас бага 375,000 дирхам (102,110.28 ам.доллар)-аас их
Эстони (Estonian tax and Customs board, 2025)	0% 22%	- Хуваарилагдаагүй ашиг, дахин хөрөнгө оруулсан ашигт - Хуваарилагдсан ашиг

Судалгаанд авагдсан улс орнуудын ААНОАТ-ын стандарт хувь хэмжээ 0%-25 байна. Хамгийн бага хувь хэмжээ нь Эмират болон Ирланд улсад 9% болон 12.5% байгаа бол хамгийн өндөр хувь хэмжээ нь Хятад улсад 25% байна. Итали улс орон нутагт ААНОАТ 3.9% ногдуулж байна. Ирланд, Вьетнам зэрэг улсууд ялгавартай ААНОАТ-ын хувь хэмжээг мөрдөж байна. Хамгийн сонирхол татахуйц улс нь Эстони бөгөөд тус улсад ААНОАТ-ын стандарт хувь хэмжээ 0% бөгөөд энэ нь хуваарилагдаагүй ашиг болон дахин хөрөнгө оруулсан ашигт хамаарна. Хэрэв ашиг хуваарилбал 22%-ийн татвар ногдуулж байна. Үүний үр дүнд Эстони улсад урт хугацааны өсөлтийг хадгалах боломжтой бизнесийн таатай орчин бүрдэж, ААН-үүдийг ашиг хуваарилалгүй харин тухайн компанидаа дахин хөрөнгө оруулалт хийх сэдлийг өгч байна. Энэхүү арга барил нь ашиг хуваарилалттай эсэхээс үл хамааран жил бүрийн цэвэр ашигт татвар ногдуулдаг уламжлалт тогтолцооноос эрс ялгаатай бөгөөд эдийн засгийн өсөлтийг идэвхжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт татахыг зорьж буй орнуудад Эстони улсын тогтолцоо нь татварын шинэчлэлийн жишиг судлагдахуун болж байна.

Эстонийн бизнесийн салбар өсөхийн хэрээр тус улсын ДНБ ч мөн адил өсөж, 2000 онд 5.69 тэрбум евро байсан бол 2021 онд ойролцоогоор 37.2 тэрбум евро болж нэмэгджээ (World Bank, 2023). 2015-2021 оны хооронд хөрөнгө оруулагчид Эстонид төвтэй гарааны бизнесүүдэд нийт 2.62 тэрбум евро оруулсан нь Төв болон Зүүн Европын бүс нутагтаа хамгийн өндөр үзүүлэлт байв (Economist Impact, 2024).

Олон улсын туршлагад ААНОАТ-ын хувь хэмжээг бууруулах урамшуулал түгээмэл хэрэглэгддэг бөгөөд голчлон хөгжиж буй орнууд өргөн хүрээтэй хэрэглэж байна.

Судалгаанд авагдсан улс орнуудын ААНОАТ-ын хувь хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж буй салбаруудын талаар дэлгэрэнгүй авч үзье.

Хүснэгт 3. Судалгаанд авагдсан улсуудын татварын стандарт болон хөнгөлөлттэй хувь хэмжээ, хөнгөлөлт үзүүлж буй салбарууд

Улс	Стан-дарт %	Татварын хөнгөлөлт үзүүлэх аж ахуйн нэгжүүд, татварын хөнгөлөлт	
Вьетнам (Vietnam Briefing, 2025)	20%	- ХАА, ойн аж ахуй, мал аж ахуй, загасны аж ахуй эрхэлж буй; - ач холбогдол бүхий нийгэм, эдийн засгийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн; - эдийн засгийн тусгай бүсэд хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулж буй; - засгийн газраас дэмжлэг үзүүлэх салбарт хөрөнгө, оруулалт хийж, үйл ажиллагаа явуулж буй; - өндөр чанарын гангийн үйлдвэрлэл, эрчим хүч хэмнэх бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй; - нийгэм, эдийн засгийн хөгжил сул бүс нутагт хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулж буй.	17% 10% 10% 10% 17% 10%
Ирланд (Revenue, Irish tax and Customs, 2025)	12.5%	Татварын хөнгөлөлттэй хувь хэмжээ хэрэглэдэггүй.	-
Итали (PwC, 2025)	24%	Ашгаа дахин хөрөнгө оруулалт хийсэн.	20%
Казахстан (PwC, 2024)	20%	ХАА-н салбарын аж ахуйн нэгжүүд.	6%
Хятад (PwC, 2025)	25%	- шаардлага хангасан өндөр технологийн үйлдвэрлэл; - программ хангамж болон бичил чип үйлдвэрлэл; - шаардлага хангасан өндөр технологийн үйлчилгээ үзүүлж буй;	15% 10% 15%

		- 3 сая юаны орлого бүхий жижиг ААН (2028 он хүртэл); - байгаль орчны бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй; - зарим бүс нутаг болон эдийн засгийн тусгай бүсэд.	5% 15% 15%
Орос (Deloitte, 2020)	20%	- электроникийн үйлдвэрлэл болон мэдээлэл технологийн үйлдвэрлэл; - Холбооны 51 муж, холбооны бүрэлдэхүүнд ордог улсуудад үйл ажиллагаа явуулж буй; - Арктикийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй; - нийгэм, эдийн засгийн тэргүүлэх хөгжлийн бүс болон Владивостокийн чөлөөт боомтын бүсэд үйл ажиллагаа явуулж буй; - бүс нутгийн хөгжлийн төсөлд оролцож буй.	3% 13.5% 0% 13% 0%
Эмират (PwC, 2024)	9%	эдийн засгийн тусгай бүсэд хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулж буй.	0%
Эстони (Estonian tax and Customs board, 2025)	0%	0%-ийн татвартай.	-

ААНОАТ-ын хувь хэмжээг бууруулах хөнгөлөлтийг хөгжиж буй бүх улсад хэрэгжүүлж байна. Хамгийн олон төрлийн бууруулсан хувь хэмжээг Хятад, Вьетнам зэрэг улсууд үзүүлж байна. Казахстан улсын хувьд ХАА-н зарим төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд үзүүлж байна. Орос улс мэдээлэл технологийн болон эрүүл мэндийн салбарт 0%, орон нутаг болон эдийн засгийн тусгай бүсэд 0-15.5%-ийн ААНОАТ ногдуулж байна. Харин хөгжингүй орон болох Ирланд улс ААНОАТ-ын бууруулсан хувь хэмжээг хэрэглэдэггүй бол Итали улс 2025 оноос эхлэн хуваарилагдаагүй ашиг болон ашгаа дахин хөрөнгө оруулсан бол 20%-ийн татвар ногдуулж эхэлсэн.

2.2 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

ААНОАТ-ын хөнгөлөлт нь ихэвчлэн хөрөнгө оруулалтын зардлыг түргэн хугацаанд нөхөх боломжийг хөрөнгө оруулж буй ААН-д олгодог. Төлбөл зохих татвараас шууд хөнгөлөх, мөн хөрөнгө оруулалтын болон зардлын (судалгаа хөгжүүлэлт, тоног төхөөрөмж, байгальд ээлтэй технологийн гэх мэт) тодорхой хувиар тооцож хөнгөлөлт үзүүлэх гэсэн хоёр хэлбэртэй байна.

Татварын хөнгөлөлт болон чөлөөлөлт нь хоорондоо ялгаатай ойлголтууд бөгөөд дараах үндсэн ялгаанууд байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Хөнгөлөлт болон чөлөөлөлтийн ялгаа

	Хөнгөлөлт	Чөлөөлөлт
бизнест үзүүлэх дэмжлэг	Татварыг тодорхой хувиар бууруулна.	Татвараас бүрэн чөлөөлнө.
татвар төлөлт	Татвар бага хэмжээгээр төлнө.	Татвар төлөхгүй.
хугацаа	Ихэнхдээ тодорхой хугацаатай, мөн тодорхой нөхцөл хангасан тохиолдолд эдэлнэ.	Зарим тохиолдолд байнгын, зарим тохиолдолд тодорхой хугацаатай байна.

Эх сурвалж: (CBPP, 2020)

ААНОАТ-ын хөнгөлөлт нь аж ахуйн нэгжийн төлөх татварын хэмжээг багасгах, харин чөлөөлөлт нь татвар төлөх үүргээс бүрэн чөлөөлөх зорилготой байдаг.

Судалгаанд авагдсан улс орнууд дээр дурдсан 2 хэлбэрийн ААНОАТ-ын хөнгөлөлт болон чөлөөлөлтийг хэрхэн хэрэгжүүлж буй туршлагыг Хүснэгт 5, 6-д харуулав.

Хүснэгт 5. Судалгаанд авагдсан улсуудын төлбөл зохих татварын хөнгөлөлт болон чөлөөлөлтийг хэрэгжүүлж буй туршлага

Тухайн улсын татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх аж ахуйн нэгжүүд	Төлбөл зохих татвараас хөнгөлөх, чөлөөлөх
Вьетнам - ХАА, ойн аж ахуй, мал аж ахуй, загасны аж ахуй эрхэлж буй; - ач холбогдол бүхий нийгэм, эдийн засгийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн; - эдийн засгийн тусгай бүсэд хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулж буй; - засгийн газраас дэмжлэг үзүүлэх салбарт хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулж буй; - нийгэм, эдийн засгийн хөгжил сул бүс нутагт хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд. (Vietnam Briefing, 2025)	- 2-4 жилийн хугацаанд татвараас **чөлөөлөх;** - 4-9 жилийн хугацаанд төлбөл зохих татварын **50%**-ийг хөнгөлөх.
Ирланд - KDB (Knowledge Development Box) хөтөлбөрт хамаарагдсан инновац, мэдлэгт суурилсан бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг; - орлого олох зорилгоор байгаль орчинд ээлтэй ойн аж ахуйн бизнес эрхэлж буй аж ахуйн нэгжүүд. (Revenue, Irish tax and Customs, 2025)	- татварын **20%**-ийг хөнгөлөх; - байгаль орчинд ээлтэй ойн аж ахуйн менежментийн орлогыг татвараас **чөлөөлөх**.
Итали Италид үйлдвэрлэлээ шилжүүлсэн аж ахуйн нэгжүүд (PwC, 2025), (Italian trade agency, 2025)	- 5 жилийн хугацаанд татварын 50%-ийг хөнгөлөх.
Казахстан эдийн засгийн чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд (PwC, 2024)	- ААНОАТ-аас **чөлөөлөх.**
Хятад - ХАА, ойн аж ахуй, мал аж ахуй, загасны аж ахуй эрхэлж буй; - зорилтод суурь дэд бүтцийн төсөлд оролцож буй; - эдийн засгийн тусгай бүсэд үйл ажиллагаа явуулж буй шаардлага хангасан өндөр технологийн үйлдвэрлэл; - 130, 65, 28 нанометрээс бага хэмжээтэй 10-15 жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа явуулах чип үйлдвэрлэгч; - чип үйлдвэрлэлийн дизайн, материал, тоног төхөөрөмж, сав баглааны үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй; - зорилтод чип үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй; - зорилтод программ хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй; - эрчим хүч, ус хэмнэх технологийг нэвтрүүлж байгаа болон байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй; - эрчим хүч хэмнэх үйлчилгээ үзүүлж буй; - нүүрс хүчлийн хий ялгаруулалтыг бууруулах төслийн; - Шинжань мужийн ядуу бүс нутаг болон эдийн засгийн тусгай бүсэд; - зарим бүс нутаг болон эдийн засгийн тусгай бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд. (China briefing, 2025), (PwC, 2025)	- 3-10 жилийн хугацаанд татвараас чөлөөлөх; - 3-5 жилийн хугацаанд төлбөл зохих татварын 50%-ийг хөнгөлөх; - ХАА, загас агнуурт төлбөл зохих татварын 50%-ийг хөнгөлөх.
Орос - Арктикийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй;	- 5-10 жилийн хугацаанд татвараас **чөлөөлөх.**

- нийгэм, эдийн засгийн тэргүүлэх хөгжлийн бүс болон Владивостокийн чөлөөт боомтын бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд(Deloitte, 2020).	

Судалгаанд авагдсан улсуудын туршлагаас харахад, хөгжиж буй орнууд ихэвчлэн, нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий салбар, хөдөө аж ахуй, эдийн засгийн тусгай бүс болон орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр төлбөл зохих татвараас хөнгөлөлт үзүүлэх хандлага харагдаж байна. Харин хөгжингүй орнуудын хувьд инновац, өндөр технологи, байгальд ээлтэй технологийн хувьд татвараас хөнгөлөх бодлого барьж байна.

Хүснэгт 6. Судалгаанд авагдсан улсуудын хөрөнгө оруулалт болон зардлын хувиар татварын хөнгөлөлт үзүүлж буй туршлага

Тухайн улсын татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх аж ахуйн нэгжүүд	Татварын хөнгөлөлт
Ирланд - судалгаа, хөгжүүлэлтэд хөрөнгө оруулалт хийж буй; - Ирланд улсад кино хийж буй; - цахим тоглоом хөгжүүлэлт хийж буй; - KDB (Knowledge Development Box) хөтөлбөрт хамаарагдсан инновац, мэдлэгт суурилсан бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг. (Revenue, Irish tax and Customs, 2025)	хөрөнгө оруулалт болон судалгаа, хөгжүүлэлтийн зардлын **30%-32%**
Итали - 4-р үеийн аж үйлдвэрлэлийг (Industry 4.0) хөгжүүлж буй; - 5.0 шилжилтийн хүрээнд эрчим хүч хэмнэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэхэд 50 сая евро хүртэл хөрөнгө оруулж буй; - Өмнөд Италийн мужуудад 100 сая евро хүртэл хөрөнгө оруулж буй; - судалгаа, хөгжүүлэлтэд хөрөнгө оруулж буй; - хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд. (PwC, 2025), (Italian trade agency, 2025)	хөрөнгө оруулалт болон судалгаа, хөгжүүлэлтийн зардлын **5%-45%**.
Казахстан эдийн засгийн тусгай бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид. (PwC, 2024)	7-25 жилийн хугацаанд хөрөнгө оруулалтын **100%**
Хятад эрчим хүч, ус хэмнэх болон байгаль орчинд ээлтэй тоног төхөөрөмжийн худалдан авалт хийсэн аж ахуйн нэгжид. (China briefing, 2025), (PwC, 2025)	хөрөнгө оруулалт болон судалгаа, хөгжүүлэлтийн зардлын **10%.**

Судалгаанд авагдсан 8 улсаас Ирланд, Итали, Казахстан, Хятад зэрэг улсууд хөрөнгө оруулалт болон зардлын хувиар татвараас хөнгөлөлт үзүүлэх туршлагыг хэрэгжүүлж байна. Эдгээр улс орнуудаас хөгжингүй орнууд нь судалгаа ба хөгжүүлэлт, өндөр технологи, байгальд ээлтэй технологи, урлагийн салбарыг дэмжиж татварын хөнгөлөлт үзүүлж байгаа бол хөгжиж буй улс Казахстаны хувьд эдийн засгийн тусгай бүсэд татварын хөнгөлөлт үзүүлж, хөрөнгө оруулалт татах бодлого баримталж байна.

Улс орнуудын туршлагаас харахад хөгжиж буй орнууд ААНОАТ-ын шууд хөнгөлөлтийг үзүүлж байгаа бол хөгжингүй улсууд хөрөнгө оруулалт болон зардлын хувиар төлбөл зохих татвараас хасуулж байна. Ирланд, Итали, Казахстан, Хятад зэрэг 4 улсын хувьд төлбөл зохих татвараас шууд хөнгөлөх болон хөрөнгө оруулалт, зардлын хувиар хөнгөлөлт үзүүлэх хэлбэрүүдийн хоёуланг нь хэрэглэж байна.

2.3 Улс орнуудын хэрэгжүүлж буй хурдасгасан элэгдэл хорогдол тооцох, зардлыг нэмэгдүүлэх урамшуулал

ААНОАТ-ын хувь хэмжээг бууруулах болон төлбөл зохих ААНОАТ-ыг хөнгөлөх, чөлөөлөх нь аж ахуйн нэгжийн татварыг бууруулж байгаа урамшуулал бол хурдасгасан элэгдэл, хорогдол болон зардлыг нэмэгдүүлэх нь татвар ногдох орлогыг багасгах замаар аж ахуйн нэгжийн бодит татварын хувийг бууруулдаг.

Хүснэгт 7. Судалгаанд авагдсан улсуудын хурдасгасан элэгдэл хорогдол тооцох, зардлыг нэмэгдүүлэх хөнгөлөлтийг хэрэгжүүлж буй туршлага

Улс	Хурдасгасан элэгдэл хорогдол	Зардлыг нэмэгдүүлэх
Ирланд (PwC, 2025)	Эрчим хүч хэмнэх машин тоног төхөөрөмжийн хувьд 100% (стандарт 4%-12.5%) элэгдэл хорогдлын зардлыг тооцуулж эхний жилдээ татвар ногдох орлогоос хасуулж болно.	
Итали (Invest in Italy, 2025)		- R&D зардлыг 210% тооцож татвар ногдох орлогоос хасуулж болно. - Байнгын ажлын байр бий болгосонтой холбогдох зардлыг 120% тооцож татвар ногдох орлогоос хасуулж болно.
Хятад (PwC, 2025)	- R&D тоног төхөөрөмжийн хувьд 100% (стандарт 10%-33.3%) элэгдэл хорогдлын зардлыг тооцуулж татвар ногдох орлогоос нэг удаа хасуулж болно. - Үл хөдлөх хөрөнгөд оруулсан ХО-ын хувьд 100% (стандарт 5%) элэгдэл хорогдлын зардлыг тооцуулж татвар ногдох орлогоос нэг удаа хасуулж болно. - Биет бус хөрөнгийн өртгийг 200%-220% тооцож элэгдэл хорогдлыг нэмэгдүүлэн тооцно.	Биет бус хөрөнгө бий болгохтой холбоотой R&D зардлыг 200%-220% нэмэгдүүлэн тооцож татвар ногдох орлогоос хасуулна.
Орос (Deloitte, 2020)		- Үл хөдлөх хөрөнгөд оруулсан ХО-ын хувьд орон нутгийн татварын 90% хүртэл, холбооны татварын 10% хүртэл хэмжээнд татвар ногдох орлогоос хасуулж болно. - Судалгаа шинжилгээний зардлыг 150% нэмэгдүүлэн тооцож татвар ногдох орлогоос хасуулна.

Судалгаанд хамрагдсан 8 улсаас Ирланд, Итали, Хятад, Орос зэрэг 4 улс хурдасгасан элэгдэл, хорогдол болон нэмэгдүүлсэн зардлын урамшууллыг хэрэгжүүлж байна. Урамшууллын хувьд судалгаа, хөгжүүлэлтийн зардлыг нэмэгдүүлж татвар ногдох орлогоос хасуулах урамшуулал хамгийн түгээмэл байна. Ихэвчлэн шинэ технологи, инновац нэвтрүүлэх болон биет бус хөрөнгийг бүтээхтэй холбоотой зардал, хөрөнгө оруулалтад хурдасгасан элэгдэл, хорогдол болон зардал нэмэгдүүлэх ААНОАТ-ын урамшууллыг үзүүлж байна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтыг татах өрсөлдөөн нэмэгдэж улс орнууд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг эрчимтэй явуулж байна. Улс орнуудын татварын урамшууллын бодлого нь тухайн улсын эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, тэргүүлэх ач холбогдол бүхий салбарыг хөгжүүлэх стратеги зэргээс шалтгаалан ялгаатай байна.

Судалгаанд авагдсан улс орнуудын хувьд хөгжингүй улс орнууд илүү хөрөнгө оруулалт, зардалд чиглэсэн татварын урамшууллын бодлогын хүрээнд шинэ технологи, инновацын судалгаа хөгжүүлэлт, ногоон эдийн засгийг бий болгоход илүү хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж байна. Харин хөгжиж буй орнууд орлогод чиглэсэн татварын урамшууллын бодлогын хүрээнд эдийн засгийн тусгай бүсэд хөрөнгө оруулж, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд олон төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтүүдийг үзүүлж байна.

Харин улс орнуудын ААНОАТ-ын хувь хэмжээ тухайн улсын эдийн засгийн бодлого, татварын тогтолцооноос хамааран ялгаатай байна. Судалгаанд авагдсан улс орнуудаас хамгийн бага хувь хэмжээтэй ААНОАТ ногдуулдаг улс Эмират (0%-9%), хамгийн өндөр нь Хятад (25%) байна. Энэхүү хувь хэмжээнээс тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл, салбараас хамааран бууруулсан хувь хэмжээгээр татвар ногдуулдаг байна. Тухайлбал, Казахстан хөдөө аж ахуйн зарим төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд (6%), Орос мэдээлэл технологийн салбарт (3%), эдийн засгийн тусгай бүсэд Хятад (15%), Орос (13%), Вьетнам (10%), Эмират (0%) зэрэг улсууд татварын хөнгөлөлт үзүүлж байна.

Хятад, Ирланд, Итали, Орос улсууд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх хэлбэрүүдийг хослуулан хэрэглэж байна. Эстони улс бүх салбарт 0%-ийн ААНОАТ тогтоосон. Эмират улс татварын хөнгөлөлт үзүүлэх салбаруудад 0%-ийн ААНОАТ ногдуулж байна.

Татварын урамшууллын бодлого нь нэг талаас хөрөнгө оруулалт, бизнесийг дэмжих боловч нөгөө талаас татварын орлогыг багасгадаг. Энэ нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх гол хэрэгсэл болох төсвийн бодлогын цар хүрээг хумьж байдаг. Тиймээс татварын урамшууллын бодлогыг хэрэгжүүлэхдээ бизнесийг дэмжих бодлого болон төсвийн бодлого хоорондын тэнцлийг хангах нь чухал гэж судлаачид үзэж байна.

НОМ ЗҮЙ

Deloitte (2020). *Survey of Global Investment and Innovation Incentives, Russia.* Хандах: https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/global/Documents/Tax/dttl-tax-survey-of-global-investment-and-innovation-incentives-russia-2020.pdf Хандсан огноо: 2025-02-03.

Economist Impact (2024). *Estonia's super-simple tax system gives growing companies an edge.* Хандах: https://impact.economist.com/projects/investing-in-estonia/ Хандсан огноо: 2025-02-15.

Estonian Tax and Customs Board (2025). *Tax rates.* Хандах: https://www.emta.ee/en/business-client/taxes-and-payment/income-and-social-taxes/tax-rates Хандсан огноо: 2025-02-12.

Invest in Italy (2025). *Incentives.* Хандах: https://www.investinitaly.gov.it/en/doing-business/incentives Хандсан огноо: 2025-02-22.

PwC (2024). *Kazakhstan Corporate - Taxes on corporate income.* Хандах: https://taxsummaries.pwc.com/kazakhstan/corporate/taxes-on-corporate-income Хандсан огноо: 2025-02-05.

PwC (2025). *China, Corporate - Deductions.* Хандах: https://taxsummaries.pwc.com/peoples-republic-of-china/corporate/deductions Хандсан огноо: 2025-02-09.

PwC (2025). *China, Corporate - Taxes on corporate income.* Хандах: https://taxsummaries.pwc.com/peoples-republic-of-china/corporate/taxes-on-corporate-income Хандсан огноо: 2025-02-18.

PwC (2025). *Ireland Corporate - Taxes on corporate income.* Хандах: https://taxsummaries.pwc.com/ireland/corporate/taxes-on-corporate-income Хандсан огноо: 2025-02-14.

PwC (2025). *Italy Corporate - Tax credits and incentives.* Хандах: https://taxsummaries.pwc.com/italy/corporate/tax-credits-and-incentives Хандсан огноо: 2025-02-21.

PwC (2025). *Italy Corporate - Taxes on corporate income.* Хандах: https://taxsummaries.pwc.com/italy/corporate/taxes-on-corporate-income Хандсан огноо: 2025-02-11.

PwC (2025). *United Arab Emirates Corporate - Taxes on corporate income.* Хандах: https://taxsummaries.pwc.com/united-arab-emirates/corporate/taxes-on-corporate-income Хандсан огноо: 2025-02-17.

Revenue Irish Tax and Customs (2024). *Reliefs and Exemptions.* Хандах: https://www.revenue.ie/en/companies-and-charities/reliefs-and-exemptions/index.aspx Хандсан огноо: 2025-02-07.

Revenue Irish Tax and Customs (2025). *Corporation Tax (CT).* Хандах: https://www.revenue.ie/en/companies-and-charities/corporation-tax-for-companies/corporation-tax/basis-of-charge.aspx Хандсан огноо: 2025-02-25.

SADC, IUCN & UNNCD (2022). *SADC Drought Risk Management and Mitigation Strategy 2022-2032.*

Stotsky, J. (2024). *Tax Incentives and Investment.* ADB. Хандах: https://www.adb.org/sites/default/files/publication/939871/governance-brief-054-tax-incentives-investment.pdf

Trading Economics (2025). *Russia Corporate Tax Rate.* Хандах: https://tradingeconomics.com/russia/corporate-tax-rate Хандсан огноо: 2025-02-20.

Vietnam Briefing (2024). *Tax Incentives for Foreign Enterprises in Vietnam.* Хандах: https://www.vietnam-briefing.com/doing-business-guide/vietnam/taxation-and-accounting/tax-incentives-for-businesses?switch_site=vb Хандсан огноо: 2025-02-08.

Vietnam Briefing (2025). *Corporate Income Tax in Vietnam.* Хандах: *https://www.vietnam-briefing.com/doing-business-guide/vietnam/taxation-and-accounting/country-wise-tax-structure/corporate-income-tax?switch_site=vb* Хандсан огноо: 2025-02-16.

World Bank (2023). *GDP (current US$) - Estonia.* Хандах: *https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.CD?locations=EE* Хандсан огноо: 2025-02-04.